



**ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХҮҮДИЙН ГАЛЫН АЮУЛГҮЙ
БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨТ ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**

Нэг. Хяналт шалгалтын зорилго

Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль тогтоомж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын стандарт норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах төлөвлөгөөт хяналт шалгалтыг гэр хорооллын айл өрхүүдэд зохион байгуулж, болзошгүй эрсдэлийг бууруулахад оршино.

Хоёр. Ерөнхий зүйл

2.1. Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын үндсэн дүрэм, гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг нь уг шалгалтыг явуулах эрх зүйн үндэс болно.

2.2. Хяналт шалгалтад оролцох бүрэлдэхүүн дээрх хууль тогтоомж, галын аюулгүй байдлын норм нормативын баримт бичиг болон энэхүү удирдамжийг баримтлан ажиллана.

2.3 Хяналт шалгалтыг зохион байгуулах явцдаа Коронавируст цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас гаргасан тогтоол, шийдвэр, Улсын онцгой комисс, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тавьж байгаа заавар, зөвлөмж, халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөнө.

2.4. Хяналт шалгалтыг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн А/235 дугаар тушаалаар баталсан "Гэр хорооллын айл өрхөд галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас"-аар хяналт шалгалтыг зохион байгуулж дүнг зөрчилтэй айл өрх тус бүрээр удирдамжийн 3.5-д заасан хаягаар цахим хэлбэрээр ирүүлнэ.

2.5. Удирдамж болон гэр хорооллын айл өрхөд гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудсыг nema.gov.mn Газар хэлтэс, Гал түймэртэй тэмцэх газар, Гал түймрийн улсын хяналт цэснээс татаж авна.

2.6. Хяналт шалгалт хийсэн тухай мэдээллийг улсын хяналтын байцаагчийн өдөр тутмын ажлын мэдээний цахим бүртгэлийн программын мэдээллийн санд нэг бүрчлэн оруулсан байна.

Гурав. Хяналт шалгалт явуулах хугацаа, зардал

3.1. Хяналт шалгалтын нийслэлийн ажлын хэсгийг онцгой байдлын ерөнхий газрын мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн нар, орон нутгийн ажлын хэсгийг Онцгой байдлын газар, хэлтсийн дарга томилон удирдлагаар хангаж, гамшгаас хамгаалах болон гал түймрийн улсын хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтан зохион байгуулна.

3.2. Гэр хорооллын айл өрхүүдэд хяналт шалгалтыг хийхдээ тухайн орон нутгийн онцгой байдлын байгууллагын бүх офицер, ахлагч бүрэлдэхүүнийг томилон ажиллуулна.

3.3. Хяналт шалгалт явуулахад шаардлагатай зардлыг тухайн орон нутгийн Онцгой байдлын байгууллага хариуцна.

3.4. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2021 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийн өдрүүдэд зохион байгуулна.

3.5. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүн, мэдээг 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын Гал түймрийн улсын хяналтын хэлтсийн Hyanaltinheltes.obeg@yahoo.com, Гамшгийн шуурхай удирдлагын газрын b.myagmarsuren@nema.gov.mn цахим хаягаар тус тус зөрчлийг фото зургаар баримтжуулан илтгэх хуудсын хамт ирүүлнэ.

Дөрөв. Хяналт шалгалтын үр дүн, авах арга хэмжээ

4.1. Хяналт шалгалтын талаарх мэдээлэл, зөвлөмж, зааварчилгыг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын вэб хуудсанд байршуулж олон нийтэд хүргэх ажлыг зохион байгуулна.

4.2. Онцгой байдлын ерөнхий газраас хяналт шалгалтын дүн, санал дүгнэлтийн талаарх танилцуулгыг шалгалтад хамрагдсан байгууллагуудын харьяалах төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж шаардлагатай арга хэмжээг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шат дараатай авч хэрэгжүүлнэ.

4.3. Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнг Гал түймэртэй тэмцэх газар, Гамшгийн шуурхай удирдлагын газар тус тус нэгтгэн дүгнэж, Онцгой байдлын ерөнхий газрын дарга бөгөөд улсын хяналтын ерөнхий байцаагчид танилцуулж, холбогдох яам, агентлаг, газрын дарга нарт улсын хяналтын ерөнхий байцаагчийн танилцуулга, мэдэгдэл, заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлэн биелэлтийг хангуулна.

ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР